



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/304

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "г", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөшөөтийн уурхайд гадаад тээвэр хийж буй жолооч тээвэрчдээс ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Ганзориг	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Ганзориг	- Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч
	Б.Эрдэнэцэцэг	- Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн халдвар хамгаалалтын улсын байцаагч
	П.Гантуяа	- МоЭнКо ХХК-д гэрээгээр нүүрс тээвэрлэгчдийн үйлдвэрчний эвлэлийн хорооны Хуулийн зөвлөх
Нарийн бичгийн дарга:	Д.Эрдэнэбат	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Хөшөөтийн уурхайд гадаад тээвэр хийж буй жолооч тээвэрчдээс ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр хяналт шалгалтын удирдамж батлуулан, хяналт шалгалт хийж шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 1671